

**КАЗАХСТАН УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ  
ТАТВАР (РОЯЛТИ)-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА**

Г.Билгээ

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

Бүгд Найрамдах Казахстан Улсад роялти буюу ашигт малтмалын нөөц ашигласны татварыг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Татварын тухай хуулиар<sup>222</sup> зохицуулах ба энэ хууль 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Өмнөх Татварын тухай хуулийг 2008 онд баталж байжээ.

Ашигт малтмалын нөөц ашигласны татварын ерөнхий хувь хэмжээ 15 хувь байна. Зарим ашигт малтмалын төрөл, олборлолтын хэмжээнээс хамаарч татварын хувь хэмжээг янз бүрээр тогтоосон байна. Тухайлбал, газрын тосны хувьд олборлолтын хэмжээнээс хамаарч **5-18 хувь**, түүхий хийн олборлолтын татвар **10 хувь** ба хэрэв дотоодын зах зээлд түүхий хий борлуулах бол түүний олборлолтын хэмжээнээс хамаарч **0,5-1,5 хувь**, мөн зарим ашигт малтмал болон түүхий эдийн төрлөөс хамаарч 0-16,2 хувь байна.

2017 оны Татварын тухай хуулиар тогтоосон ашигт малтмалын нөөц ашигласны татварын хувь хэмжээг 2008 оны хуультай<sup>223</sup> харьцуулахад өөрчлөгдөөгүй байна.

**СУДАЛГААНЫ ХЭСЭГ**

**КАЗАХСТАН УЛСЫН АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ  
ТАТВАР (РОЯЛТИ)-ЫН ХУВЬ ХЭМЖЭЭ**

Ашигт малтмалын олборлолт, техногенийн хуримтлалын боловсруулалтын үйл явцад газрын хэвлий ашиглахад ашигт малтмалын нөөц ашигласны татварыг ногдуулах<sup>224</sup> ба татварын хувь хэмжээ 15 хувь<sup>225</sup> байна.

Татварын тухай хуулийн 743.1-д **газрын тосны олборлолтын** татварын хувь хэмжээг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

*Хүснэгт 1. Газрын тосны олборлолтын татварын  
хувь хэмжээ*

| №   | Жилийн олборлолтын<br>хэмжээ | Татварын<br>хувь хэмжээ |
|-----|------------------------------|-------------------------|
| 1.  | 250 000 тонн хүртэл          | 5                       |
| 2.  | 500 000 тонн хүртэл          | 7                       |
| 3.  | 1 000 000 тонн хүртэл        | 8                       |
| 4.  | 2 000 000 тонн хүртэл        | 9                       |
| 5.  | 3 000 000 тонн хүртэл        | 10                      |
| 6.  | 4 000 000 тонн хүртэл        | 11                      |
| 7.  | 5 000 000 тонн хүртэл        | 12                      |
| 8.  | 7 000 000 тонн хүртэл        | 13                      |
| 9.  | 10 000 000 тонн хүртэл       | 15                      |
| 10. | 10 000 000 тонноос дээш      | 18                      |

Хэрэв газрын тосыг Казахстан Улсын дотоод зах зээлд борлуулах<sup>226</sup> бол ашигт

<sup>222</sup> Кодекс Республики Казахстан от 25 декабря 2017 года №120-VI «О налогах и других обязательных платежах в бюджет (Налоговый кодекс)». Эх сурвалж: <https://online.zakon.kz>

<sup>223</sup> Кодекс Республики Казахстан от 10 декабря 2008 года №99-IV «О налогах и других обязательных платежах в бюджет (Налоговый кодекс)». Эх сурвалж: <https://online.zakon.kz>

<sup>224</sup> Татварын тухай хуулийн 1.1.52.

<sup>225</sup> Татварын тухай хуулийн 646.1.5.

<sup>226</sup> Татварын тухай хуулийн 739.2.1-4.

малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг 0.5 коэффициентоор бууруулна<sup>227</sup>.  
Үүнд:

**Түүхий хийн олборлолтын** татварын хувь хэмжээ нь 10 хувь байх ба хэрэв түүхий хийг дотоодын зах зээлд борлуулах бол жилийн олборлолтын хэмжээнээс хамаарч татварын хувь хэмжээг дараах байдлаар тогтоосон байна<sup>228</sup>. Үүнд:

*Хүснэгт 2. Түүхий хийн олборлолтын татварын хувь хэмжээ*

| №  | Жилийн олборлолтын хэмжээ   | Татварын хувь хэмжээ |
|----|-----------------------------|----------------------|
| 1. | 1,0 тэрбум куб метр хүртэл  | 0,5                  |
| 2. | 2,0 тэрбум куб метр хүртэл  | 1,0                  |
| 3. | 2,0 тэрбум куб метрээс дээш | 1,5                  |

Татварын тухай хуулийн 746 дугаар зүйлд зааснаар **ашигт малтмал, түүхий эдийн олборлолт** (үүнд анхан шатны боловсруулалт хийгдсэн ашигт малтмал, түүхий эд орно)-д ашигт малтмалын нөөц ашигласны татварын дараах хувь хэмжээг тогтооно.<sup>229</sup> Үүнд:

*Хүснэгт 3. Ашигт малтмал, түүхий эдийн олборлолтын татварын хувь хэмжээ*

| №  |   | Ашигт малтмал, түүхий эд (үүнд зөвхөн анхан шатны боловсруулалт хийгдсэн ашигт малтмал, түүхий эд орно)-ийн нэр | Татварын хувь хэмжээ |
|----|---|---|----------------------|
| 1. | Хар, өнгөт болон цацраг идэвхт металлын хүдэр | Хромын хүдэр (баяжмал)  | 16,2                 |
|    |   | Мангантай болон төмөр-мангантай хүдэр (баяжмал)   | 2,5                  |
|    |   | Төмрийн хүдэр (баяжмал)   | 2,8                  |
|    |   | Уран  | 18,5                 |
| 2. | Металл  | Мангантай болон төмөр-мангантай хүдэр (баяжмал)   | 5,7                  |
|    |   | Төмрийн хүдэр (баяжмал)   | 7,0                  |
|    |   | Уран  | 8,0                  |
|    |   | Алт, мөнгө, цагаан алт, паллади   | 5,0                  |
|    |   | Хөнгөн цагаан   | 0,25                 |
|    |   | Цагаан тугалга  | 3,0                  |
|    |   | Никель  | 6,0                  |
| 3. | Металл агуулсан эрдэс түүхий эд               | Ванади  | 4,0                  |
|    |   | Хром, титан, магний, кобальт, вольфрам, бисмут, сурьма, мөнгөн ус, хүнцэл болон бусад                           | 6,0                  |
| 4. | Ховор металл агуулсан эрдэс түүхий эд         | Ниобий, лантан, церий, циркони  | 7,7                  |
|    |   | Галий   | 1,0                  |
| 5. | Сийрэг металл агуулсан эрдэс түүхий эд        | Селен, теллур, молибден   | 7,0                  |
|    |   | Скандий, германий, рубиди, цезий, кадмий, индий, талли, гафний, рени, осмий                                     | 6,0                  |
| 6. | Цацраг идэвхт металл агуулсан эрдэс түүхий эд | Родий, торий  | 5,0                  |
| 7. | Ховор металл агуулсан эрдэс түүхий эд         | Лити, берилли, тантал, стронци  | 7,7                  |
| 8. | Газрын ховор металл                           | Празеодим, неодим, прометий, самарий,   | 6,0                  |

<sup>227</sup> Татварын тухай хуулийн 743.1.

<sup>228</sup> Татварын тухай хуулийн 743.1.

<sup>229</sup> Татварын тухай хуулийн 746.

|   |   |  |      |
|---|---|--|------|
|   | агуулсан эрдэс түүхий эд                        | европий, гадолийн, тербий, диспрозий, гольмий, эрбий, тулий, иттербий, лютений, иттрий                                     |      |
| Металл бус хатуу ашигт малтмал агуулсан эрдэс түүхий эд |   |  |      |
| 9.  | Түлш, химийн болон агрономийн эрдэс түүхий эд   | Чулуун нүүрс, хүрэн нүүрс, шатдаг занар  | 0    |
|   |   | Фосфорит   | 4,0  |
|   |   | Борын хүчил (үүнд борын ангидрит хамаарна)   | 3,5  |
|   |   | Кали болон кали-магнийн давс   | 6,0  |
|   |   | Бари   | 4,5  |
|   |   | Стеатит  | 2,0  |
|   |   | Гипс   | 5,6  |
|   |   | Хүхэр  | 6,0  |
|   |   | Хайлуур жонш   | 3,0  |
|   |   | Воластанит   | 3,5  |
|   |   | Шунгит   | 2,0  |
|   |   | Графит болон бусад   | 3,5  |
| Өнгөт чулуун түүхий эд                                  |   |  |      |
| 10.   | Үнэт чулуу агуулсан эрдэс түүхий эд             | Алмаз, бадмаараг, индранил, маргад, анар, александрит, улаан (эрдэнийн) шпинель, эвклаз, молор, усан биндэрьяа болон бусад | 12,0 |
| 11.   | Гоёл чимэглэлийн чулуу агуулсан эрдэс түүхий эд | Нефрит, хас, хаш, номин, радонит, малахит, авантюрин, гартаам, уулын болор, кварц, оюу, дипотаз, мана болон бусад          | 3,5  |
| 12.   | Үйлдвэрлэлийн чулуу агуулсан эрдэс түүхий эд    | Техникийн алмаз, гартаам, корунд, циркон, хас, серпентинит, асбест, гялтгануур болон бусад                                 | 2,0  |
| 13.   | Бусад металл бус эрдэс түүхий эд                | Хөнгөн цагаан агуулсан чулуу (хээрийн жонш, пегматит)  | 2,5  |
|   |   | Калорин, вермикулит, бусад металл бус хатуу ашигт малтмал, металл бус эрдэс түүхий эд                                      | 4,7  |